



МОНГОЛБАНК

МОНГОЛ УЛСАД ИРЖ БУЙ ЖУУЛЧДЫН ЗАРДЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА¹

Түүвэр судалгаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээр дамжуулан **711** жуулчныг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамрууллаа. Судалгааны зарим үр дүнгээс дурдахад жуулчид Монголд байх хугацаанд **800-2100** ам.долларыг зарцуулж байгаа бөгөөд энэ нь одоогоор төлбөрийн тэнцэл боловсруулахад ашиглагдаж буй дунджаас **30-150** хувиар өндөр байна.

I. Өмнөтгөл

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистикт аялал жуулчлалын үйлчилгээтэй холбогдох орлого зарлагыг үйлчилгээний дэд дансанд бүртгэдэг билээ. Төлбөрийн тэнцлийн статистикийн хамрах хүрээ, мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2011 онд “Монгол Улсад ирж буй жуулчдын зардлын судалгаа”-г Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран, тус холбооны гишүүн байгууллагуудыг хамруулж, анкетийн аргаар мэдээлэл цуглууллаа. Судалгааны анкетийг тараах, цуглуулах ажилд туслалцаа үзүүлсэн Монголын Аялал Жуулчлалын холбоо, түүний гишүүн байгууллагуудад талархал илэрхийлье.

II. Судалгааны аргазүй

2.1 Судалгааны зорилго


Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсын аялал жуулчлалаас олж буй орлогыг тодорхойлох, улмаар уг үзүүлэлтийг Монгол Улсын Төлбөрийн тэнцлийн статистикт ашиглахад оршино. Одоогоор төлбөрийн тэнцэл дэх аялал жуулчлалын салбарын орлогыг тодорхойлохдоо Аялал жуулчлалын хөгжлийн хүрээлэнгийн профессор, доктор Д.Гансүхээр удирдуулсан судалгааны багийн 2004 онд хийсэн судалгааны дүнд суурилж ВЭЗГ-ын тооцоолсон гадаадын жуулчдын дундаж зардал болон Хил хамгаалах ерөнхий газраас сар бүр ирүүлдэг “Монгол улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын судалгаа”-г аялал жуулчлалын салбарын статистик мэдээллийн эх сурвалж болгож байна. Гэвч сүүлийн жилүүдийн гадаад орчны эдийн засгийн байдал, дотоодын инфляци зэргээс шалтгаалан дундаж зардлын хэмжээг 2004 оны судалгааны дүнд суурилах нь учир дутагдалтай тул үүнийг шинэтгэн тогтооход судалгааны зорилго оршино.

¹ Валют, эдийн засгийн газар, ТТССХ, 327086, tuvshingerel@mongolbank.mn

2.2 Ерөнхий мэдээлэл

Сүүлийн 4 жилийн төлбөрийн тэнцэл дэх аяллын үйлчилгээний статистикийн дүрслэл 1) үзвэл Монгол Улсын гадаад иргэдэд үзүүлсэн аялал жуулчлалын үйлчилгээнээс олсон орлого нь Монгол иргэдийн гадаадад аялсан зардлаас бага байгаа нь харагдаж байна. 2011 оны хувьд сөрөг тэмдэгтэй 126.3 сая ам.долларын тэнцэлтэй байгаа бөгөөд үүний 52% нь аялал, амралтын чанартай жуулчлалаас үүдэн гарсан байна. 2011 онд тус оны ДНБ-ний 1.47%-тай тэнцэх хэмжээний гадаад валютыг аялал жуулчлалын шугамаар гадаадад гаргасан статистик тооцоололтой байна.

Дүрслэл 1: Төлбөрийн тэнцэл дэх аяллын үйлчилгээ



Хүснэгт 1: 2005 оноос хойшхи жуулчдын хандлага


Улс орон	2005	2010	2011	2005/2010	2010/2011
Австрали, Шинэ Зеланд	2941	4415	4763	50.12%	7.88%
АНУ, Канад	8375	11204	11489	33.78%	2.54%
БНСУ	2557	34238	33247	1238.99%	-2.89%
ХБНГУ	6346	6376	6054	0.47%	-5.05%
ИБУИНВУ	3977	5205	4877	30.88%	-6.30%
Франц	5021	7054	6583	40.49%	-6.68%
Япон	10756	11744	10887	9.19%	-7.30%
Баруун Европын бусад орнууд ²	9341	14996	13725	60.54%	-8.48%
Бусад бүх орнууд	185059	222886	221646	20.44%	-0.56%
Нийт	234373	318118	313271	35.73%	-1.52%

Монгол Улсын хилээр орсон жуулчдын статистикаас (хүснэгт 1) үзвэл 2005-2010 оны хооронд жуулчдын тоо 35.73%-аар өссөн боловч 2010-2011 оны хооронд буурчээ. 2011 оны “Бусад бүх орнууд” ангилалд багтах жуулчдын 66% нь буюу нийт жуулчдын 46% нь БНХАУ-ын жуулчид байна.


² Испани, Португал, Нидерланд, Бельги, Андорра, Люксембург, Швед, Норвег, Финланд, Австри, Дани, Швейцар, Итали, Лихтенштейн, Малта, Кипр, Грек (+ Исланд, Ирланд 2011)

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь амралт, жуулчлалын зорилгоор Монголд ирсэн бөгөөд түүн дотроос Монголын онгон дагшин байгаль, зэрлэг ан амьтан, уламжлалт зан заншил, соёлд татагдан ирсэн жуулчид 70 орчим хувийг эзэлж байна.

Дүрслэл 5: Асуулт 1. Таны Монголд айлчилж буй аяллын үндсэн зорилго юу вэ?



Дүрслэл 6: Асуулт 2. Таны Монгол Улсыг сонгон айлчлах болсон гол шалтгаан юу вэ?



Хүснэгт 2: Асуулт 3. Монголын талаарх мэдээлэл олж авсан мэдээллийн гол эх үүсвэр тань юу вэ?

Эх үүсвэр	Хувийн жин
Веб хуудас, интернэт	28%
Аяллын хөтөчийн ном	21%
Найз нөхөд, хамаатан садан	20%
Аяллын агент, тур оператор	13%
Өмнөх айлчлал	8%
Телевиз, радио, сонин	5%
Аялал, жуулчлалын сэтгүүлүүд	5%
Бусад	1%

Хүснэгт 3: Асуулт 5, 6. Та хэдүүлээ аялж байгаа вэ?

Аялал	Том хүн	Хүүхэд	Хувийн жин
Ганцаараа			14%
Гэр бүлээрээ	3	2	24%
Групп жуулчидтай	8	2	62%
Нийт дундаж	7	2	100%

Монголыг зорьж буй ихэнх жуулчид мэдээллийн эх сурвалжийг аяллын хөтчийн ном, найз нөхөд хамаатан садан, аяллын тур агентуудаас авч байна. Судалгаанд хамрагдсан нийт жуулчдын дийлэнх хувь нь групп жуулчидтай аялсан байгаа нь аялал жуулчлалын чиглэлийн аж ахуйн нэгжүүдээр дамжуулан түүвэрлэлт хийсэнтэй холбоотой байх магадлалтай юм.

Хүснэгт 4: Асуулт 4, 7. Таны аяллын үргэлжлэх хугацаа хэдэн өдөр вэ? Та багц аялалд хамрагдсан уу, аль эсвэл өөрөө аялалаа зохион байгуулсан уу?

Хугацаа	Багц аялал	Хувийн аялал	Нийт	Хувийн жин
1-3 хоног	14	6	20	2.8%
4-7 хоног	218	66	284	39.9%
8-14 хоног	72	95	167	23.5%
15-21 хоног	108	58	166	23.3%
22-оос дээш	27	47	74	10.4%
Нийт	439	272	711	100.0%
Хувийн жин	62%	38%	100%	-


Жуулчид дунджаар 4-21 хоногийн хугацаатайгаар Монголд ирж байгаа бөгөөд дийлэнх нь багцын аялалд хамрагддаг байна. Улс тус бүрээр авч үзвэл хамгийн удаан хугацаатайгаар зорчдог нь Герман болон Францууд бөгөөд удаан хугацаагаар зорчдог аялагчид ихэвчлэн бие даан аяллаа зохион байгуулдаг байна.

Хүснэгт 5: Асуулт 8. Аяллын дундаж зардал (ам.доллараар⁴)

Харьяалал	Багц аялал	Хувийн аялал	Дундаж	Зардлын харьцаа (Багц / Хувийн)
Австрали, Шинэ Зеланд	2356	1483	2138	1.6
АНУ, Канад	3194	1356	2170	2.4
БНСУ	1433	1046	1312	1.4
ИБУИНВУ	2516	1157	2158	2.2
Франц	3709	624	3113	5.9
ХБНГУ	4338	1348	1528	3.2
Япон	2829	1532	2546	1.8
Баруун Европын бусад орнууд	2672	1230	2179	2.2
Бусад	3138	878	1604	3.6
Дундаж	2490	1156	1979	2.2

Багцын аяллын зардал нь хувиараа зохион байгуулсан аяллаас дунджаар 2.2 дахин их байдаг тооцоолол гарсан. Гэвч энэ нь багц аяллын хувьд олон улсын агаарын тээврийн зардал, болон зуучилсан байгууллагын үйлчилгээний шимтгэл шингэсэн байдагтай холбоотой бөгөөд төлбөрийн тэнцэлд ашиглагдах дундаж дүнг тооцоходоо энэ бүхнийг харгалзан гаргах шаардлагатай.


Дүрслэл 7: Асуулт 8. Монголд ирснээс хойшхи аяллын зардлын задаргаа (ам.доллараар)



Жуулчдын Монголд ирснээс хойш зарцуулсан зардлын бүтцийг харвал багцын аялалд хамрагдагсдын хувьд хоол болон бэлэг дурсгалын зүйлд мөнгөө зарцуулдаг бол хувиараа аялагчдын хувьд дийлэнхийг зочид буудал болон хоол, дотоодын тээвэрт зарцуулдаг байна.


⁴ Гадаад валютын ханшийг Монголбанкны 2011 оны дундаж ханшаар хөрвүүлэн тооцсон.

Дүрслэл 7: Асуулт 9. Та Монголын аялал жуулчлалын үйлчилгээг ерөнхийд нь хэрхэн үнэлэх вэ?




Жуулчид үйлчилгээний төрөл тус бүрд 1-ээс 5-ын хооронд оноо тавьж үнэлгээ өгсөн бөгөөд хамгийн өндөр үнэлгээг тур операторын үйлчилгээний чанарт өгч, хамгийн бага үнэлгээг бусад үйлчилгээний төрлүүдэд өгчээ. Бусад үйлчилгээний төрөлд ихэвчлэн аюулгүй байдаг, замын тэмдэглэгээ зэрэг асуудлууд хамрагджээ.


Дүрслэл 8: Асуулт 10. Монголд хийж буй аялалаа ерөнхийд нь дүгнэвэл?



Дүрслэл 9: Асуулт 11. Та дахин Монголд ирэх үү?



Дүрслэл 10: Асуулт 12, 13 Та энэхүү аяллыг бусад санал болгох уу? Таны санаанд хүрсэн үү?



Асуулт 14. Сайжруулахад анхаарах зүйлс.

- Автозам, замын хөдөлгөөн
- Хөтөч
- Буудал, нийтийн газрын ариун цэвэр
- Үйлчилгээний харилцааны соёл
- Зам, газрын тэмдэглэгээ
- Англи хэлний мэдлэг
- Халуун ус
- Музей, түүхэн үзмэрийн газар
- Хоолны чанар
- Хотын аюулгүй байдал

Асуулт 10-14 нь тухайн жуулчны Монголд хийсэн аяллын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлоход чиглэсэн бөгөөд ойролцоогоор 80 хувь нь тодорхой хэмжээнд сэтгэл хангалуун гэсэн хариултыг өгсөн бөгөөд тэдгээр хүмүүсийн хандлага нь Монголд дахин ирэх сонирхолтой, цаашилбал найз нөхөддөө Монголын аяллыг санал болгоно гэжээ. Харин Монголын аялалд муу үнэлгээ өгсөн жуулчдын хувьд үүнээс эсрэг хандлагатай байна. Асуулт 14-ын хариултуудаас харахад юуны түрүүнд Монголын автозамын дэд бүтцийн хангалтгүй байдал нь жуулчдад сөрөг сэтгэгдэл төрүүлдэг байна. Мөн буудал, олон нийтийн газрын ариун цэврийн хангалтгүй байдал, зуны улирлын буудлуудын халуун усны тасралт, хөтчийн үнэ өндөр боловч чанар муутай байдаг гэсэн шүүмжлэлүүдийг өгчээ. Эдгээр асуудлуудад анхаарлаа хандуулж, үйлчилгээний чанарыг сайжруулахгүй бол жуулчдын тоо буурах хандлага байгааг Хүснэгт 1 харуулсан билээ.

IV. Тооцоолол


Санал асуулгаас гарсан жуулчдын дундаж зардлын дүн нь хувийн аялагчдын хувьд ашиглагдаж болох боловч багцын аялалд хамрагдсан жуулчдын хувьд шууд төлбөрийн тэнцэлд ашиглах боломжгүй юм. Учир нь багцын аяллын үнэд жуулчлалын байгууллагын үйлчилгээний шимтгэл болон олон улсын зорчигч тээврийн зардал багтсан байдаг. Иймээс багцын аяллаар жуулчилж байгаа жуулчдын Монгол Улсад оруулсан гадаад валютын орлогыг тооцож гаргахдаа дараах төлбөрүүдийг хасч тооцооллоо.

- Олон улсын агаарын тээврийн зардал⁵
- Гадаадын тур оператор болон тур агентад ноогдох ашгийн хувь⁶

Хүснэгт 6: Жуулчдын дундаж зардлын тооцоолол, ам.доллараар

Улс орнууд	Багц аялал		Хувийн аялал		Дундаж	Жуулчдын тоо	2011 оны орлого /саяар /
	Дундаж	62%	Дундаж	38%			
Австрали, Шинэ Зеланд	742	458	1483	567	1025	4'763	4.88
АНУ, Канад	1344	830	1356	519	1348	11'489	15.49
БНСУ	643	397	1046	400	797	33'247	26.51
ИБУИНВУ	1285	794	1157	442	1236	4'877	6.03
Франц	2090	1291	624	239	1529	6'583	10.07
ХБНГУ	2560	1581	1348	516	2097	6'054	12.69
Япон	1356	837	1532	586	1423	10'887	15.49
Баруун Европын бусад орнууд	1375	849	1230	471	1319	13'725	18.11
Бусад	1677	1036	878	336	1372	221'646	304.01
Нийт						313'271	413.28

Дүрслэл 11: 2011 онд жуулчлалын салбараас олсон орлогыг 2004 болон 2011 оны судалгааны дундажар тооцсон харьцуулалт



⁵ Онгоцны зардлыг тодорхойлохдоо олон улсын агаарын зорчигч тээврийн нэгдсэн мэдээллийг өгдөг “www.kayak.com”-ын үнийг ашиглалаа. Ингэхдээ 2 талын зардлын хамгийн бага утгын 85 хувиар тооцсон болно. Жуулчны байгууллагууд агаарын тээврийн компанитай гэрээ байгуулсан байдаг бөгөөд хатуу нөхцлөөр олон тасалбарыг хямдруулж авдаг учир бага дүнгээр тооцсон болно.

⁶ Үйлчилгээний шимтгэл буюу гадаадын тур агентлагуудад ноогдох ашгийн хувийг 30%-аар тооцлоо. 2004 оны судалгааны хувьд уг ногдол ашгийг 70%-аар тооцож байсан байна. Гэвч интернетээр дамжуулан жуулчид шууд Монголын байгууллагад хандах нь ихэссэн тул хувийг багасгаж тооцлоо.

Хүснэгт 7: Жуулчдын дундаж зардлын тооцоолол, ам.доллараар

Улс орнууд	2005	2011	Өсөлт
Австрали, Шинэ Зеланд	567	1025	81%
АНУ, Канад	958	1348	41%
БНСУ	618	797	29%
ИБУИИНВУ	850	1236	45%
Франц	831	1529	84%
ХБНГУ	844	2097	149%
Япон	567	1423	151%
Баруун Европын бусад орнууд	861	1319	53%
Бусад	642	1372	114%

V. Дүгнэлт

Тухайн жуулчны иргэншлээс хамааран аялалд зарцуулах дундаж зардал харилцан адилгүй байгаа бөгөөд 800-2'100 ам.доллар байна. Энэ нь одоогоор төлбөрийн тэнцэлд ашиглагдаж буй 2004 оны судалгаанд суурилсан дундаж зардлаас 30-150%-аар өндөр дүн бөгөөд 2004 оноос хойшхи Монгол Улсын эдийн засгийн өөрчлөлт, инфляцийн өсөлттэй харьцуулвал харьцангуй бага өсөлт гэж хэлж болохоор байна.

2011 онд жуулчлалын салбараас олсон гадаад валютын орлогыг 2004 болон 2011 оны судалгааны дунджаар тооцоолвол харгалзан 200.00 болон 413.28 сая ам.доллар (Дүрслэл 11) байна. Өөрөөр хэлбэл шинэ судалгааны үр дүнг ашиглаж эхэлснээр зөрүү дүн болох 213.28 сая ам.доллартай тэнцэх хэмжээний харьяат бусад үзүүлсэн жуулчлалын үйлчилгээг тайлант онд нөхөж бүртгэх, хугацааны цувааг залруулснаар жуулчлалын үйлчилгээний статистикийг сайжруулах боломжтой байна.

Гадаад жуулчдын ойролцоогоор 80 орчим хувь нь Монголд хийсэн аяллаас сэтгэл дүүрэн буцаж байгаа бол үлдсэн 20 хувь нь тодорхой хэмжээгээр шүүмжлэлтэй хандсан байна. Автозамын дэд бүтэц, хөтөч, үйлчилгээний соёлыг сайжруулахгүй бол жуулчдын тоо үүнээс хойш багасах магадлалтай байна.